



**Арилжааны мэдээ**

- Монголын хөрөнгийн бирж 2019 оны 8 дугаар сарын 19-ны өдрөөс 2019 оны 8 дугаар сарын 23-ний өдрүүдэд 4 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, өдөрт дунджаар 100 сая төгрөг буюу нийт 501,541,024.49 төгрөгийн арилжаа хийсэн байна.
- 2019 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,499,776,495,409.15 төгрөг болсон бол “ТОП 20” индекс 19522.19 нэгж болж өмнөх долоо хоногоос 2,37% хувиар буурсан үзүүлэлттэй байна.

MSE Top 20 индекс

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа

Эх сурвалж: Монгол Банк

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

Зах зээлийн өөрчлөлт

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	19522.19	-2,37%
MSE A индекс	9042.33	-1,99%
MSE B индекс	7820.33	-1.08%

Зах зээлийн хураангуй**Нийт (MNT)**

Зах зээлийн үнэлгээ	2,499,776,495,409.15
Арилжигдсан үнийн дүн	502 сая төгрөг

Үнийн дүнгээр**Хаалт (MNT)****Мөнгөн дүн**

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	1352.00	211,848,412.00
ТАВАН ТОЛГОЙ ХК	6840.00	118,902,450.00
ГОВЬ ХК	277.82	35,575,331.68
АПУ ХК	520.00	21,885,766.70
ИНВЕСКОР ББСБ ХК	1909.00	20,890,827.00

Тоо ширхэгээр**Хаалт (MNT)****Нийт**

ЛЭНДМН ББСБ ХК	54.59	209,813.00
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	1352.00	154,237.00
ГОВЬ ХК	277.82	125,443.00
РЕМИКОН ХК	26.00	122,500.00
МОНОС ХҮНС ХК	68.00	87,057.00

Ханш өссөн**Хаалт (MNT)****% Өөрчлөлт**

ХҮРД ХК	4279.00	15.00%
ЖЕНКО ТУР БЮРО ХК	70.00	11.09%
МОГОЙН ГОЛ ХК	7990.00	6.53%
ГЕРМС ЦЕНТР ХК	127.54	6.28%
МОНГОЛ ШЕВРО ХК	1800.00	4.65%

Ханш буурсан**Хаалт (MNT)****% Өөрчлөлт**

ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК	189.00	-14.09%
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	1352.00	-9.81%
БИ ДИ СЕК ХК	833.22	-7.42%
РЕМИКОН ХК	26.00	-7.14%
ТАЛХ ЧИХЭР ХК	17020.00	-5.44%

Дараах link-ээр орж арилжааг харна уу: <http://bdsec.mn/trade/>

ЭНЭ ДОЛОО ХОНОГТ**“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН 2018 ОНЫ НОГДОЛ АШИГ ИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ДАНСАНД БАЙРШУУЛАА. (schcd.mn)**

“Могойн гол” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд хуваарилах 1,205.36 төгрөгөөс албан татвар суутгасан дүн 1,084.82 төгрөгийн ногдол ашгийг 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЖЭЭ. (schcd.mn)

“Гермес Центр” ХК нь 2019 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5.70 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Тус компани нь 2019 оны хагас жилээр 481 сая төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд нийт цэвэр ашгийн 93% буюу 447,695,105.7 төгрөгийг “ҮЦТХТ” дэх хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд байршуулахаар болсон байна.

“ХЯНАН ШАЛГАГЧИД ЗОРИУЛСАН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ГАРЫН АВЛАГА”-ЫГ БАТАЛЛАА. (frc.mn)

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) чиглэлээр бодлого боловсруулах, улс орнуудад зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий байгууллага болох Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-аас гаргадаг 40 зөвлөмжийн 26-д заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь МУТСТ-д тавигддаг шаардлагуудыг хэрхэн биелүүлж байгааг хянаж шалгах, зохицуулахад чиглэгдсэн арга хэмжээг авч ажиллах ёстой.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 327 дугаар тогтоолоор баталсан “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд “Санхүүгийн зохицуулах хороо салбарын эрсдэлийн үнэлгээг зайнаас хийж, холбогдох хяналт шалгалт хийх заавар, журам, гарын авлагыг боловсруулна” гэж заасан байдаг. Үүнтэй холбоотой Хорооноос 2018 оны 239 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”, журмыг дагалдуулж холбогдох тайлан мэдээлэх заавар, өгөгдөл цуглуулах маягт, үнэлэх асуулга, эрсдэлийн үнэлгээний матриц зэрэг баримт бичгүүдийг баталсан.

Хорооноос мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд мөнгө угаах болон терроризмтой тэмцэх чиглэлээр зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг тогтмол явуулж ирсэн хэдий ч хянан шалгагчид нь газар дээрх хяналт шалгалтыг явуулахад зориулсан нарийвчилсан гарын авлага батлагдаагүй. Газар дээрх хяналт шалгалтыг илүү цогц, чамбай болгох зорилгоор Хорооны хянан шалгагч нарт зориулан “МУТСТ чиглэлээр газар дээрх хяналт шалгалт хийх” гарын авлагыг баталлаа.

“ЭНЕРЖИ РЕСУРС”-ЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО 20% ӨСЖЭЭ. (ikon.mn)

Mongolian Mining Corporation (MMC) буюу Энержи Ресурс компанийн 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн мэдээлэл өчигдөр албан ёсоор нийтлэгджээ.

Тайлант хугацаанд тус компани 2.5 сая тонн баяжуулсан нүүрсэн бүтээгдэхүүн экспортолсон бөгөөд борлуулалтын орлого нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 20 орчим хувиар өсч, 325.6 сая ам.доллар буюу одоогийн ханшаар 870 орчим тэрбум төгрөгт хүрсэн байна. Компанийн нийт ашгийн хэмжээ эхний хагас жилд 129.9 сая ам.доллар буюу одоогийн ханшаар 347 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны эхний хагас жилийнхээс 20 орчим хувийн өсөлт үзүүлжээ. Мөн хувь эзэмшигчдэд хамаарах ашгийн хэмжээ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс бараг 60 орчим хувиар өсч, 47.1 сая ам.долларт хүрсэн байна.

Энержи Ресурс нь нүүрсийг түүхийгээр бус баяжуулсан бүтээгдэхүүн хэлбэрээр экспортолдог. Энэ утгаараа коксжих нүүрсний экспортын үнийг Монголоос хамгийн өндөр тогтоож ирсэн. 2019 оны эхний хагаст тус компанийн баяжуулсан коксжих нүүрсний борлуулалтын үнэ тонн тутамд дунджаар 147 ам.доллар байжээ.

МХБ-ИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ. (mse.mn)

Монголын Хөрөнгийн Биржийн 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тойм тайлан гарсан байна.

Эхний хагас жилийн үзүүлэлтүүдээс онцлох 5 мэдээллийг нь хүргэе.

- Хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 376.9 сая ширхэг хувьцааг 82.3 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 79.8 мянган ширхэг үнэт цаасыг 7.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 90.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

- МХБ нь хагас жилийн хугацаанд хамгийн олон буюу 4 компанийн үнэт цаасыг шинээр бүртгэж, анхдагч зах зээлд нийт 42.5 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад даруй 3 дахин өссөн үзүүлэлт болжээ.

- Бүртгэлтэй компаниудын үүргийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, арилжаа нь зогссон 22 компанийг бүртгэлээс хассан байна.

- Хөрөнгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх үүднээс нийт 5 аймагт нээлттэй өдөрлөг зохион байгуулж, 7,000 гаруй иргэдийг хамруулжээ.

- Санхүүгийн үзүүлэлтийн хувьд Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй хэдий ч нийтдээ 994.4 сая төгрөгийн орлого олж, 716.9 сая төгрөгийн зардал гаргаснаар нийт 277.4 сая төгрөгийн цэвэр орлоготой ажилласан ба МП цогц системийн ашиглалтын зардал болон элэгдэл, хорогдолд нийт 482.1 сая төгрөгийн зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайландаа татварын өмнөх байдлаар 204.6 сая төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөд байна. Улсын төсөвт нийт 274.9 сая төгрөгийн татвар, шимтгэлийг төлсөн нь өмнөх оны мөн үеэс 25.1%-аар өссөн үзүүлэлт болсон байна.



О.Уранбайгаль

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Д.Шүрэнцэцэг

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: shurentsetsegd@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Б.Онон

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: Onon.b@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.